



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ШИНЭЖИНСТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2024 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 08

Залаа


Сумын Засаг даргын 2024-2028 оны үйл
ажиллагааны хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1 дэх заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2.Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэхийг сумын Засаг дарга (Л.Батхуяг)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Т.Цэнгэлмаа)-д даалгасугай.



ДАРГА

Н.САЙХАНБАЯР

642401074

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны
2024 оны 12 дугаар сарын 30 ны өдрийн
08 дугаар тогтоолын 01 дүгээр хавсралт

ШИНЭЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Зорилго: Иргэдийнхээ ая тухтай, амгалан тайван орчинд амьдрах, ажилтай, орлоготой байх нөхцөлийг хангаж, чадвартай, ил тод, идэвх санаачилгатай, авлига, ашиг сонирхлын зөрчилгүй, иргэдийн оролцоо, итгэл дэмжлэгийг хүлээсэн, цахимд ил тод, нээлттэй нутгийн удирдлагын хариуцлагатай тогтолцоог төлөвшүүлсэн жишиг сум болно.

НЭГ. НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1.Эрүүл мэнд: -Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг сурталчилж, зөв дадал хэвшилтэй иргэдийн тоог нэмэгдүүлнэ.

1.1.1.Зөв хооллолт, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, бие бялдраа хөгжүүлэх дасгал хөдөлгөөн хийх, уур бухимдлаа удирдах зэрэг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг ард иргэдэд сурталчилж эрүүл мэндийн мэдлэг олгох, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааг үе шаттай зохион байгуулна.

1.1.2.Хорт зуршлаас зайлсхийж амьдралын зөв дадал хэвшилтэй болсон иргэдийг шагнаж урамшуулах, нийгэмд сурталчилан нөлөөлөх аянд оролцуулна.

1.1.3.Эрт илрүүлэгийн үзлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэхэд салбар дундын оролцоо, хамтын ажиллагааг сайжруулна.

1.1.4.Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгааныг бууруулан, иргэдийн эрүүл мэндийг дэмжиж, "Эрүүл иргэн - Хонгорын баялаг" арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.1.5.Эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, нэн шаардлагатай боловсон хүчин, тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлнэ.

1.2.Боловсрол: -Хүүхдэд ээлтэй, эрүүл аюулгүй, хөгжих ая тухтай орчыг бүрдүүлэн боловсролын чанарын үнэлгээг дээшлүүлж, эрдэм боловсролтой, ёс суртахуунтай иргэнийг төлөвшүүлнэ.

1.2.1.Сургууль, цэцэрлэгийн орчин, үйлчилгээний чанарыг сайжруулж хүүхдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, сурч хөгжих, хамгаалуулах, оролцох эрхийг хангана.

1.2.2.Боловсролын чанарын үнэлгээ, багш нарын мэдлэг чадварыг дээшлүүлэх, өндөр ёс зүйтэй өөрөөрөө үлгэрлэсэн багшийг бий болгох сургалт нөлөөллийн ажлыг тогтмол явуулж хүүхдийн хэрэгцээ, шаардлагыг хангасан “Чадварлаг багш” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.2.3.Сургуулийн спорт заал, дотуур байр, цэцэрлэгийн барилгад их засвар хийж стандартын хангалт, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.2.4.Цэцэрлэг, сургуулийн үдийн хоолны чанар, стандартад хяналт тавьж хүүхдийг шим тэжээлээр баялаг хүнс, “өдөр бүр нэг аяга сүү”-гээр хангах хөтөлбөрийг аж ахуйн нэгжийн дэмжлэгтэй хэрэгжүүлнэ.

1.2.5.Улс, аймаг, бүсийн чанартай уралдаан, тэмцээн, олимпиадад оролцох сурагчдыг дэмжинэ.

1.3.Нийгмийн бодлого, хөдөлмөр халамж:- Гэр бүлийн хөгжил, хамгааллыг сайжруулж нийгмийн соён гэгээрүүлэх эерэг хандлагыг төлөвшүүлнэ.

1.3.1.Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг төлөвшүүлнэ.

1.3.2.Хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхжүүлж нийгмийн зорилтот бүлэгт хүрэх үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.3.3.Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлнэ.

1.3.4.Хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх чиглэлээр нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулна.

1.3.5.Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж нийгмийн оролцоог нэмэгдүүлнэ.

1.3.6.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлж тэгш хүртээмжтэй үйлчилгээ авах стандартыг мөрдүүлнэ.

1.3.7. Ажилтныг тэтгэвэрт гарахад бэлтгэх, ахмад настны хөгжил, хамгааллыг сайжруулах санал, санаачилгыг дэмжиж, ахмадуудыг хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг, туршлагыг нь залуу үед хүргэх, ахмад настны зөвлөх үйлчилгээг өргөжүүлнэ.

1.3.8.Иргэдийн туршлага, ур чадварт түшиглэн хувиараа хөдөлмөр эрхлэх боломжийг дэмжиж инновацид суурилсан гарааны бизнест чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

1.4.Соёл, урлаг, спорт: -Бүх нийтийн соёлын боловсрол арга хэмжээг хэрэгжүүлж иргэдийг соёлын бүтээгдэхүүн үйлчилгээгээр идэвхжүүлнэ.

1.4.1. Урлаг, соёлоор дамжуулан хүүхэд залуучууд, иргэд, олон нийтийг соён гэгээрүүлэх, төлөвшүүлэн төгөлдөржүүлэх, нийгмийн сэтгэл зүйд эерэгээр нөлөөлөх арга хэмжээг зохион байгуулна.

1.4.2. Үндэсний соёлын биет ба биет бус өв, түүх соёлын дурсгалын хадгалалт хамгаалалтыг сайжруулан олон талт агуулгаар баяжуулж, хүүхэд залуучуудад өвлөн уламжлуулж, сурталчлан таниулж, түгээн дэлгэрүүлнэ.

1.4.3. Номын сангийн үйлчилгээг өргөжүүлж, сан хөмрөгийг баяжуулан, үндэсний цахим мэдээллийн санд нэгдэж, иргэн бүрийн ном унших дадал, хэвшлийг нэмэгдүүлнэ.

1.4.4. Соёлын төвийн барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, тохижилтыг сайжруулж орон нутгийн онцлог бүхий соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож, брэндийг хөгжүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулна.

1.4.5. Идэвхтэй хөдөлгөөн, чийрэгжүүлэх дасгал, эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн зориулалтын талбай, цогцолборуудыг байгуулан нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ.

1.4.6. Үндэсний спортын холбоодын үйл ажиллагааг бодлогоор дэмжинэ.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

2.1. Хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлж эдийн засгийн өсөлтийг сайжруулна.

2.1.1. Эдийн засгийн суурь үндэс болсон уламжлалт мал аж ахуйгаа байгальд ээлтэйгээр хөгжүүлж орон нутгийн онцлогт тохирсон цөм сүргийг өсгөн үржүүлэх ажлыг зохион байгуулна.

2.1.2. Мах бэлтгэн нийлүүлэх зорилгоор мал нядалгааны газар, мах хадгалах зоорь бий болгох ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэнэ.

2.1.3. Бэлчээр ашиглалтын хэсгүүдийн үйл ажиллагааг урамшуулан дэмжиж хамтран ажиллана.

2.1.4. Малын гаралтай түүхий эдийн анхан шатны боловсруулалт хийх хоршоог дэмжинэ.

2.1.5. Мал амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулна.

2.1.6. Бэлчээрийг зүй зохистой ашиглах, хамгаалах, сайжруулах зорилгоор инженерийн хийцтэй худгуудын хэвийн ажиллагааг хангах, шаардлагатай цэгүүдэд уст цэгийн хайгуул хийж худаг уст цэгийн тоог нэмэгдүүлнэ.

2.1.7. Мал сүрэгт ангилалт, үзлэгийг тогтвортой явуулж малын үржлийн стратегийн дагуу үржил селекцийн ажлыг явуулна.

2.1.8.Газар тариалан эрхлэлтийг олон талт байдлаар өргөжүүлж услалтын систем болон хиймэл нуурын засвар шинэчлэлтийг хийнэ.

2.1.9.Хоршоо, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүнээ үйлдвэрлэх, худалдаалах түгээх үйл ажиллагааг дэмжиж хөнгөлөлттэй зээл, төсөл хөтөлбөрт хамруулна.

2.1.10.Брэнд бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлэх зорилгоор үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүний сурталчилгааг өргөжүүлж, худалдаалах, борлуулах үйл ажиллагааг дэмжиж, үзэсгэлэн худалдаа зохион байгуулна.

2.1.11.Ажилчдын нормын хувцас, хэрэглэлийг үйлдвэрлэх зорилгоор ахуйн үйлчилгээг бий болгоно.

2.1.12.Татварын хууль тогтоомжийг сурталчлан татвар төлөгчдийн мэдлэг боловсролыг дээшлүүлж татварын бааз суурийг нэмэгдүүлэн орлогын төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллана.

2.1.13.Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж, сайн дурын үйлчилгээг даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн нэмэгдүүлнэ.

2.1.14.Худалдаа, үйлчилгээний стандарт, хангалтад хяналт тавьж, иргэдийг эрүүл аюулгүй хүнсээр хангана.

2.2.Байгаль орчны бохирдол, доройтлыг бууруулан хог хаягдлын менежментийг сайжруулж ард иргэдэд ээлтэй, үр өгөөжтэй төсөл хөтөлбөрийг дэмжих бодлогыг баримтална.

2.2.1.Хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр цуглуулах, ангилах, дахин боловсруулах, тээвэрлэх, устгах оновчтой менежментийн тогтолцоог бүрдүүлнэ.

2.2.2.Байгаль орчинд нэн шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслийг нэмэгдүүлнэ.

2.2.3.Биологийн олон янз байдлыг хамгаалах замаар амьтдын амьдрах орчныг сайжруулна.

2.2.4.Нүхэн жорлонгийн тоог бууруулж ариун цэврийн байгууламжийг нэмэгдүүлнэ.

2.2.5.Ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлж, газрын доройтол, цөлжилтийг бууруулна.

2.2.6.Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч орхигдсон газруудыг нөхөн сэргээнэ.

2.2.7.Байгаль орчинд ээлтэй, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

2.3.Инженерийн дэд бүтцийг сайжруулж орон нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлно.

2.3.1.Баянхонгор аймаг хүртэлх 230 км хатуу хучилттай авто замын ажлыг эхлүүлнэ.

2.3.2.Сумын хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөг хийлгэж хэрэгжүүлнэ.

2.3.3.Албан байгууллагуудыг төвлөрсөн цэвэр усны системд холбоно.

2.3.4.Айл өрхүүдийг төвлөрсөн дулааны шугамд холбогдох боломжийг нэмэгдүүлнэ.

2.3.5.Гудамж, талбайн гэрэлтүүлэг, камерыг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулна.

2.3.6.Гэр хорооллын өнгө үзэмжийг сайжруулж “Жишиг гудамж, хороолол” ажлыг эхлүүлнэ.

2.3.7.Багуудыг үүрэн холбооны сүлжээнд холбох ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

2.3.8.Эхийн голыг эрчим хүчээр хангана.

2.3.9.Сумын төвийн шинэчлэл төсөлд хамрагдана.

ГУРАВ. ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

3.1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, бүтээмжийг сайжруулж, ил тод нээлттэй, шударга байдлыг хангаж иргэдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлнэ.

3.1.1.Төрийн албан хаагчдын сургалт, нийгмийн баталгаа, хүний нөөцийн стратегийг боловсруулж, чадавхыг бэхжүүлж бүтээмжийг нэмэгдүүлнэ.

3.1.2.Уул уурхайн аж ахуйн нэгжүүдтэй байгуулж буй гэрээ, газар өмчлүүлэх, эзэмшүүлэх үйл ажиллагаа, худалдан авах ажиллагаа, тусгай зөвшөөрлүүдийн мэдээллийн ил тод нээлттэй байдлыг хангана.

3.1.2. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг ханган хүн ба байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхүйц хууль бус уул уурхай, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг таслан зогсооно.

3.1.3.Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын түншлэл, хамтын ажиллагааг сайжруулж зорилтот бүлэг, малчид руу чиглэсэн сайн дурын аян өрнүүлнэ.

3.1.4.Төлөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сангийн тайлагналтыг хариуцлагажуулж байгууллага, албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээг ил тод болгоно.

3.1.5."SHILEN.GOV.MN" нэгдсэн системд нээлттэй мэдээллийг байршуулж, төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангана.

3.1.6.Архивын баримтын хадгалалт хамгаалалт аюулгүй байдлыг хангана.

3.1.7.Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлж сэтгэл ханамжийг нэмэгдүүлнэ.

3.1.8.Төрийн байгууллагын барилгуудад их завсар хийж албан хаагчдын ажиллаж амьдрах ая тухтай орчинг бүрдүүлэн төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

3.1.9.Олон нийтийн үйл ажиллагаа, арга хэмжээ, цаг үеийн мэдээ, мэдээллийг тухай бүр цахимаар шууд дамжуулах нөхцлийг бүрдүүлэх, албан байгууллагуудын статистик тоо баримт, хөрөнгө оруулалт, хандив тусламж, тайлан мэдээг жил бүр "Сэтгүүл" хэлбэрээр ард иргэдэд хүргэнэ.

3.1.10.Сумын "Хүндэт дэвтэр"-ийн журмыг боловсруулан батлуулж загварыг шинэчлэн хүндэт иргэдийг алдаршуулан батламжилна.

3.1.11.Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудад ажиллаж, амьдарч буй нутгийн уугуул иргэдтэй эргэх холбоотой ажиллаж жил бүр уулзалт, арга хэмжээ зохион байгуулна.

3.1.12.Төрийн байгууллагуудад ISO 9001 стандартыг нэвтрүүлнэ.

3.1.13.Сумын түүхт 70 жилийн ойн баяр наадмыг ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлнэ.

3.1.14.Батлан хамгаалах хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлж ажиллана.

3.1.15.Гамшгаас хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж эрсдлээс урьдчилан сэргийлэх байнгын бэлэн байдлын менежментийг сайжруулна.